

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос



АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 30

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Өнгөрсөн 7 хоногт алтны ханш 0.39%-иар өслөө.

АНУ-ын богино хугацааны хүү, бондын өгөөж өндөр байгаа тул хөрөнгө оруулагчдын алт худалдан авах сонирхол буураад байна.

АНУ-ын 4 сарын үзүүлэлтээр айл өрхүүдийн бараа, үйлчилгээний худалдан авалт нэмэгдэж инфляцийн өсөлт удааширч эхэллээ. Тодруулбал, АНУ-ын хэрэглээний зардал хүлээлтээс өссөн нь эдийн засгийн уналтаас болгоомжилж байгаа энэ үед өсөлтийг дэмжих боломжтой юм.

БНХАУ бол дэлхийн хамгийн том алт хэрэглэгч орон. Тус улсад тогтоогоод байсан хөл хорио суларч байгаагаар холбогдуулан эрэлт нэмэгдэж алтны ханш өснө хэмээн шинжээчид таамаглаж байна.

Даваа гарагт дурсамжийн өдөр тохиож буй учраас холбооны засгийн газрын оффисууд, хөрөнгийн болон бондын зах зээл, Холбооны нөөцийн сан амарна.

Golomt_Capital published on TradingView.com, May 30, 2022 10:18 UTC-8

CFDs on Gold (US\$ / OZ), 10, TMC O1852.70 H1859.82 L1848.30 C1859.49 -6.65 (-0.36%)
MA (200, close, 0, SMA, 5) 1840.68
MA (50, close, 0, SMA, 5) 1899.63



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 30

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Даваа гарагт нефтийн үнэ хоёр сарын дээд түвшиндээ хүрч өслөө. Брент маркийн нефтийн фьючерс 46 цент буюу 0.4%-иар нэмэгдэж, баррель нь 119.89 ам.доллар болсон бол АНУ-ын Баруун Техасын (WTI) нефтийн үнэ 60 цент буюу 0.5%-иар өсч, баррель нь 115.67 ам.долларт хүрлээ.

Ням гарагт ЕХ-оос ОХУ-ын газрын тосны экспортод хориг тавих тал дээр тохиролцож чадаагүй ч даваа гарагийн үдээс хойшхи дээд хэмжээний уулзалтаар ОХУ-ын нефтийг далайгаар тээвэрлэхийг хориглох хэлэлцээрийг үргэлжлүүлж, хоолойгоор нийлүүлэхийг зөвшөөрнө гэж албаны хүмүүс мэдэгдэв.

Хэрэв тохиролцоонд хүрвэл Унгар, Словак, Чех улс өөр нийлүүлэлтийн гарц олдтол ОХУ-ын нефтийг "Дружба" хоолойгоор дамжуулан авах боломжтой болно.

Пүрэв гарагт хуралдах ОПЕК+ орнуудын хувьд нефтийн олборлолтоо нэмэгдүүлэх барууны уриалгыг хүлээж авахгүй байх төлөвтэй байна. Тэд 7 сард өдөрт 432,000 баррель нефть олборлох төлөвлөгөөгөө чанд баримтална хэмээжээ.

Баасан гарагт Грекийн эрэгт хадгалагдаж байсан танкерээс Ираны нефтийг АНУ хураан авсны хариуд Грекийн хоёр нефть тээвэрлэгч хөлөг онгоцыг барьцаалсан гэж Ираны тэнгисийн цэргийн хүчнээс мэдэгдээд байна.

Ингэснээр дэлхийн газрын тосны худалдааны гуравны нэгийг хангадаг Ормузын хоолойгоор дамжин өнгөрөх урсгал тасалдахад хүргэнэ гэж шинжээчид үзэж байна.

Golomt Capital published on TradingView.com, May 30, 2022 10:30 UTC+8

Light Crude Oil Futures, THX:NYMEX O114.96 H116.10 L114.86 C116.01 +0.94 (+0.82%)
 1A (5), close, 0, SMA, 5) 85.58
 1A (200), close, 0, SMA, 5) 60.77



TV TradingView

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.